



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар A/123

Булган сум

Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон  
шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/321 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Эрүүл мэндийн газрын дарга нь өөр албан тушаалд шилжин ажиллах болсонтой холбогдуулан Булган аймгийн Булган сумын өрхийн эрүүл мэндийн төвийг шинээр сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлт оруулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны газрын дарга)
Гишүүд:	Д.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Д.Отгонсүрэн (Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга)
	Д.Батдэлгэр (Эрүүл мэндийн газрын Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга)
	Ж.Оюунгэрэл (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
	Ж.Гүндэгмаа (Эрүүл мэндийн газрын анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)
	Ц.Өсөхбаяр (Цоожид өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, өрхийн эмч, мэргэжилтнүүдийн холбооны төлөөлөл, зөвшилцсөнөөр)
	Н.Амгаланбаатар (Булган сумын 3 дугаар багийн иргэний төлөөлөл)
Нарийн бичгийн дарга:	М.Солонго (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн)

6326010162

2.Өрхийн эрүүл мэндийн төвийг шинээр сонгон шалгаруулах арга хэмжээг хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/789 дүгээр захирамжийн 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР